

МУБИС-ийн Архангай аймаг дахь Багшийн сургуулийн багш,
докторант Б.Мөнхтуяа

Онтологийн метафор ба өхөөрдөл өнгө аяс

Орчин цагийн хэлшинжлэл, соёл судлал, утгазохиолыг үзэх үзэл, философи сэтгэлгээ тэргүүтэн нь эдүгээ бичиг соёлын “цөм” асуудал болох эхийн судалгаанд онцгой анхаарал хандуулах болжээ. Уран сайхны эхийн түвшний хураангуй ба дэлгэрэнгүй олон янз чимэг тодотгол ба тодруулагчийн найруулгын үүрэг, өнгө аяс, түүний утга соёл зэрэг нь тусгайлан судалмаар сонин сэдэв. Дүрслэлт чимэг тодотгол (образное определение)–ын утга, үүрэг, хэрэглээг хүний танин мэдэхүй, сэтгэлгээний үйл явц, үр дүн талаас нь шинжилсэн судалгаа төдий л олон бус бөгөөд саяхныг хүртэл монгол хэлшинжлэлд зүйрлэл, адилтгал, хэтрүүлэл, төлөөлөл, тойруулал, егөөдөл зэргийг уранзохиолын асуудалд хамруулан уран найруулгын дүрслэх хэрэглүүр гэж үзээд, өвөрмөц хэллэг, хэлц, хэвшмэл хэллэг, зүйр цэцэн үг зэргийг хэл шинжлэлийн асуудалд хамруулан судалдаг байсан билээ. Эдүгээ шууд бус нэрлэлтийг танин мэдэхүйн хэлшинжлэлд “метафор” гэсэн нэртомьёо, ухагдахууны дор судлах нь бас нэгэн шинэ чиглэл болж байна. Тухайлбал, Метафор нь хүний өдөр тутмын амьдралд байнга хэрэглэгдэж байдаг төдийгүй, яруу найраг, уранзохиолын төрөл зүйлд хүртэл арвин баялаг орсон байдаг бөгөөд Р.Якобсоны хэлснээр “Бүх үгэлбэр бол нэг бол метафорик нэг бол метонимик хэв шинжид хамаардаг байна.”¹

“Сэтгэлгээний тогтсон хэв шинж, тогтсон хэмжүүр нь тухайн соёл - хэлтэн юм үзэгдэл, үйл явдал, байдал нөхцөл, шинж чанарыг үнэлсэн үнэлэмж нь байдаг. Энэ үнэлэмж нь адилтгал, зүйрлэлээр илэрнэ.”² гэжээ.

Лакофф, Жонсоннар “Хүний сэтгэхүйн явц нь олонх тохиолдолд метафорлаг” гээд байгалийн юмс, эд зүйл, хүний бие махбодтой холбоотой туршлага дээр үндэслэсэн метафорыг онтологийн метафор гэж нэрлэсэн байна.³

Онтологийн метафор нь аливаа үйл явдал, хүний сэтгэл санаа, үйл хөдлөл, үзэл бодлыг ахуйн зүйл, юмс болгон илгээдэг.

¹ Ууганбаяр.М, Метоним, метафор хэмээх ойлголт ба эхийг унших ерөнхий загварын нэгэн жишээ, МУИС, МХСС, Монгол судлал, 2007.х.115

² Баянсан.Ж, Соёл, хэл, үндэсний сэтгэлгээ, УБ., 2002.х.31

³ Лакофф, Дж, Джонсон.М, Метафоры, котормы мы живем, УРСС., 2004.с., 24-30

Өөрөөр хэлбэл, хийсвэр, илэрхийлэхэд хүнд хэцүү нөхцөл байдал, үйл явдлыг ахуй, юмсын зүйл гэх мэт бодит ойлголтыг сурвалж талбар болгон бодьжуулдаг аж.

Тэгвэл, монгол уран сайхны эхийн найруулгад дүрслэлт (адилтгалт, зүйрлэлт) чимэг тодотголоор дамжин илэрсэн өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн өхөөрдөл өнгө аясыг онтологийн метафортой холбон авч үзвэл:

Эх сурвалж нь амьтан заасан дүрслэлт чимэг тодотгол: Тухайлбал,

Эх сурвалж нь: бүжин, ангаахай, эрвээхий

Зорилго нь: балчир, жижигхэн, өхөөрдөм

Дүрслэн буулгалт нь: тодотгогч-тодотгуулагчийн харьцаан дахь адилтгалт чимэг тодотгол

Уран сайхны эхийн жишээгээр үзүүлбэл:

...Бөртөн бөртөн зэрэглээ хормойтой минь орооцолдож,

Бүжин бор хөлийн минь сайрыг долоодог байсан. (Б.Лхагвасүрэн, "Ингэн хөөс")

...Ач хүү минь

Ангаахай жаахан үр минь

Сэвлэгээс чинь

Цээнэ, сүү хоёр үнэртэнэ.

...Эцгийнхээ балчирхан үеийг

Эгээ хэвээр нь хуулсан

Эрвээхэй жаахан ач минь (Ш.Дулмаа, "Эрвээхэй жаахан ач минь") гэх мэт.

Энэхүү урансайхны эхийн баримтад "бүжин (бор) - хөл", "ангаахай – үр минь" "эрвээхий - ач минь" гэсэн адилтгалт чимэг тодотгол нь "балчирхан, цовоо сэргэлэн" гэсэн өхөөрдөл өнгө аясыг илэрхийлж байна гэж үзэв.

Эх сурвалж нь амьгүй юм заасан дүрслэлт чимэг тодотгол: Тухайлбал,

Эх сурвалж нь: нар, алт, сувд, хас, эрдэнэ

Зорилго нь: үнэ цэнтэй, илч гэрэлтэй, эрхэм нандин

Дүрслэн буулгалт нь: тодотгогч-тодотгуулагчийн харьцаан дахь зүйрлэлт чимэг тодотгол

Урансайхны эхийн жишээ баримт нь:

“...Дунжаагийн сэтгэлийг дэвтээж, орчлонг уужим болгодог гэрэлт нар болсон^{тодотгогч} хүү нь^{тодотгуулагч} алив гай түйтгэрт өртөлгүй арван нас хүрчээ. Эх хүү хоёр бие биеэ энхрийлэн хайрлах нь туйлгүй...” (Д.Намсрай, “Буяны нүгэл”)

...Аавдаа алт болсон^{тодотгогч}

Ээждээ сувд болсон^{тодотгогч}

Энхрий булбарай бие нь^{тодотгуулагч}

Эсэн мэндээр хүмүүжиг (Ц.Дамдинсүрэн, “Хоёр настай Ро”)

...Ээжийн ганц

Эрдэнэ болсон^{тодотгогч} үр минь^{тодотгуулагч} (Монгол Жангар)

Ийнхүү хүн зонд илч дулааныг хайрладаг гэрэлт “наран”-тай, эсвэл үнэ цэнэтэй ховор “эрдэнэ”-тэй зүйрлэн жишиж, үр хүүхдээ өхөөрдөн энхрийлж, хөөршөөсөн өнгө аясыг илтгэсэн бол, дараах эхэд:

...үг хэлэлцэн хичээнгүйлэн аашлах нь бага хүүхэд мэт хөнгөмсөг зөвсэргүү, хасын өнгөтэй дөрвөлжин цагаан шүдээ үе үе яралзуулан инээмсэглэн мишээнэ. Хээр талын дунд хөндлөн гулд давхиж, хөдөөгийн саруулд биеэ гайхуулсан^{тодотгогч} ийм^{тодотгогч} нэг үзэсгэлэнт охинтой^{тодотгуулагч} учраад, хэрхэн сэтгэл хөдлөхгүй байж болох ажээ. (Д.Нацагдорж, “Хөдөө талын үзэсгэлэн”)

хэмээн дүрийн (хүний) зан ааль, цог жавхлант байдлыг дүрслэн чимэглэсэн, тоочимж цогцолбор нь өгүүлэгчийн эерэг үнэлэмжийн сайшаан магтсан, өхөөрдөн энхрийлсэн өнгө аястай байна гэж үзэв.

Эх сурвалж нь хүний бие эрхтэн заасан дүрслэлт чимэг тодотгол: Тухайлбал,

Эх сурвалж нь: хуруу, эрхий, тохой, шагай

Зорилго нь: балчир, жаахан, энхрий, өхөөрдөм

Дүрслэн буулгалт нь: тодотгогч-тодотгуулагчийн харьцаан дахь адилтгалт (хэтрүүлэлт - багасгасан) чимэг тодотгол

Уран сайхны эхийн баримтаас жишээлбэл:

...- Аан гэж хүү нь дуугарна.

Ангир ижийн хөх эвэлнэ.

Хуруун чинээ^{тодотгогч} үрийн нь^{тодотгуулагч}

Хонхны дуу үл тасарна. (Б.Лхагвасүрэн, “Уянгын тойрог”)

Эрхийн чинээ^{тодотгогч} алаг хөөрхөн үр юугаан^{тодотгуулагч}

Элэг зүрхэндээ наадууланхан тэвэрч

Энэ ертөнцийн жаргал тийш тэмүүлэгч

Эхийг хайрлах уянгын бадаг төрдөөг!(Д.Пүрэвдорж, "Эхийн тухай сэтгэгдэл")

Тохойн чинээ^{тодотгогч} үрийнхээ^{тодотгуулагч} шөнийн уйлахыг сонсож

Төрсөн эцгийн дээ авчирсан зовлон баяр хоёрыг

Тоо ёсоор нь амсаж өөрөө мэдэх гэсэн юм, би.

(Б.Явуухулан, "Алаг дэлхийд төрсөн минь учиртай")

...Охины нас бага, хувцас муу, ажил их болж, хүйтэн халуунд нүднийхээ нулимсыг өдөр бүр цувруулж, шагайн чинээ^{тодотгогч} бор гараараа^{тодотгуулагч} нүдээ нухалж явна. (Ц.Дамдинсүрэн, "Гологдсон хүүхэн") хэмээн адилтган багасгаж, дүрслэн чимэглэснээр үрхүүхдээ энэрэх хайрлах сэтгэлийн илэрхийлэл өхөөрдөн энхрийлсэн өнгө аясыг илэрхийлж байна гэж үзэв.

Энэ мэт баримтаас үүдэн дараах хэдэн дүгнэлтийг хийж байна.

1. Байгаль ертөнц, хүн ба юмс, тэдгээрийг танин мэдсэний үр дүн, үндэстний сэтгэлгээний онцлог нь тодотгогч – тодотгуулагчийн харьцаан дахь дүрслэлт чимэг тодотголоор илэрдэг нэгэн зүйл тодотгол байна.
2. Монголчуудын ахуй соёлд гэр бүлсэг байдал, эцэг эхийн элбэрэл журмыг хамгаас нандигнан эрхэмлэдэг. Монгол эцэг(эх)хүний үр хүүхдээ хайрласан сэтгэлийн илэрхийлэл, эерэг үнэлэмжийн өхөөрдөн энхрийлсэн өнгө аяс нь дүрслэлт чимэг тодотголоор дамжин илэрдгийг олон баримт харуулж байна.
3. Метафорын томъёолол талаас харвал, зүйрлэсэн, адилтгасан эх сурвалж ньэнхрий балчирхан, цовоо сэргэлэн, илч гэрэлтэй, эрхэм нандин гэсэн утгатай зорилгын хүрээг илтгэж, дүрслэн буулгалт нь тодотгогч-тодотгуулагчийн харьцаагаар илэрч байна.
4. Урансайхны эхийн найруулга дахь дүрслэлт чимэг тодотголыг эхийн нэгжүүдийн шаталсан тоолцоонд тулгуурлан харахад, дүрслэлт чимэг тодотгол – дан нэр үг, дүрслэлт чимэг тодотгол – нэрийн холбоо болон хэл, хэлэхүйн төгс нэгж дүрслэлт чимэг тодотгол – өгүүлбэр, дүрслэлт чимэг тодотгол – цогцолбор гэсэн нэгж бүрд хамаатай болох нь харагдав.

Abstract : An epithet's function is to describe a thing and it is also a "linguistic unit" that expresses positive and negative evaluation of a speaker.

The Mongolians have recognized common phenomenon, actions and features of the Universe and the whole human life cycle, and this recognition is expressed by description which relates to the describer and the person or object being described.

Similes, epithets, identifications and hyperbole used by a describer can happen in a stepped system of syntax units of the Mongolian language. They can be related to descriptive epithets in the form of single nouns, phrases, statements or complex statements.

Ном зүй

1. Артюнова.Н.Д, Языковая метафора:(Синтаксис и лексика), Лингвистика и поэтика,М.,1979
2. Баянсан.Ж, Соёл, хэл, үндэсний сэтгэлгээ, Уб., 2002
3. Баранов.А.Н, Караулов.Ю.Н, Русская политических метафора,Материалы к словарю, М.,1991
4. Гаадан.Х, Зохист аялгууны толин дахь адилтгал зүйрлэл,Уб.,1986
5. Галбаяр.Г, Уранзохиол шинжлэлийн үүд, Уб., 2003
6. Дулам.С, Хасбаатар.Ц., Уранзохиолын онолын үүд, Уб.,1980
7. Мөнх- Амгалан.Ю, Орчин цагийн монгол хэлний баймжийн ай, Уб.,1998
8. Лакофф.Дж, Джонсон.М, Метафоры которыми мы живем,//Теория метафоры, М.,1990
9. Пүрэв-Очир.Б, Монгол хэлний эх задлалын асуудлууд, Уб., 2002
10. Пүрэв-Очир.Б, Үг, өгүүлбэрийн амь амьдрал, эрчим долгион, соёл хэрэглээ, Уб., 2011
- 11.Пүрэвжанцан.А.,Үгийн утга шилжих тухайд, МУИС,МХСС, Монгол судлал, Эрдэм шинжилгээний бичиг, Уб.,1999
- 12.Ууганбаяр.М, Метоним, метафор хэмээх ойлголт ба эхийг унших ерөнхий загварын нэгэн жишээ, МУИС, МХСС, Монгол судлал,Эрдэм шинжилгээний бичиг,Уб., 2007
13. Хүрэлбаатар.Л,Эсэруагийн эгшиг дуун, Уб., 1999
14. Энхбаяр.С, Утгазохиолын онол, Уб., 2011
- 15.Ярцева.В.А, Большой энциклопедический словарь языкознания, М.,1998